



Энэхүү маягтыг бөглөхийн өмнө Картын хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлтэй танилцана уу!
Please, read the terms and conditions of the interest and commission of a Card before completing this form!
Та дараах өргөдлийг үнэн зөв гаргацтай бөглөнө үү! Please complete the form correctly and accurately

Он/ Year Cap/ Month Өдөр/ Day

Дебит картын төрөл/ Debit card type: Виза/ Visa: Цалингийн/ Payroll Энгийн/ Classic Няравын/ Treasurer Бусад/ Other
 ₮ карт/ ₮ card: Байгууллага/ Corporate Алтан/ Gold Оюутан/ Student Нийслэл/ Niislel

Хувь хүний мэдээлэл / Personal details:

 Ноён / Mr Хатагтай / Ms

Ургийн овог / Family name: Гар утас / Mobile number:
 Яс үндэс / Ethnicity: Гэрийн утас / Home number:
 Эцэг /эх/-ийн нэр / Surname: Цахим шуудан / E-mail:
 Нэр / Given name: Байнгын оршин суугаа хаяг / Permanent address:
 Регистр № / Registration №: Түр оршин суугаа хаяг / Temporary address:

Зураг / Photo

/Сүүлийн 6 сард
авахуулсан 3x4
харьцаатай/
/3x4 size photo taken
within last 6 months/

Ажил эрхлэлт / Employment:

 Ажилтай / Employed Ажилгүй / Unemployed Оюутан / Student Тэтгэвэрт / Retired Хувиараа хөдөлмөр эрхэлдэг / Selfemployed

Албан тушаал / Occupation: Ажлын утас / Office number:
 Ажлын газрын нэр, хаяг / Name and address of Employer: Факс / Fax:
 Ажилласан жил / Years of employment:

Байгууллагын болон Няравын карт авах бол байгууллагын мэдээллийг тэмдэглэнэ үү / For business and treasurer cards, fill in the company information

Байгууллагын нэр / Company name:
 Байгууллагын хаяг / Company Address:
 Эрх бүхий албан тушаалтны овог нэр / Full name of the authorized personnel:
 Албан тушаал / Job title: Баталгаат гарын үсэг / Authorised signature:
 Гар утас / Mobile number: Тамга / Seal:
 И-мэйл / E-mail:

Бусад төлбөрийн картын мэдээлэл / Information of other payment card:

1. Олгосон банк / Issuer bank: Картын төрөл / Card type:
 2. Олгосон банк / Issuer bank: Картын төрөл / Card type:
 3. Олгосон банк / Issuer bank: Картын төрөл / Card type:

Яаралтай тохиолдолд холбоо барих хүний мэдээлэл / Emergency contact details:

Овог нэр / Full name: Таны юу болох / Relationship:
 Ажлын газрын нэр, хаяг / Name and address of Employer: Гар утас / Mobile number:

Нууцлал / Confidentiality:

Харилцагчийн дансны болон картын мэдээлэлтэй холбоотой асуудлаар банктай зайнаас холбогдох үед таныг тухайн данс болон картын эзэмшигч мөн эсэхийг энэ асуулт хариултаар баталгаажуулах тул танаас өөр хүн хариулж чадахааргүй асуулт хариулт сонгон нууцыг чандлан хадгална уу.

When costumers contact the bank through the phone regarding account and card information, the following security question and answer provided by the customer will be used for identity confirmation. Please write down secret question and answer and make sure your answer is private, memorable and secure.

Асуулт / Question Хариулт / Answer

Харилцагчийн зөвшөөрөл / Customer approval

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3-т заасан Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллыг авах зорилгоор бэлэн бус гүйлгээний мэдээлэлтэй холбоотой картын дансны дугаар, регистрийн дугаар, гүйлгээний дүнг тухай бүр Татварын алба руу илгээхийг зөвшөөрч байна.

For the purpose of tax remuneration in accordance with Article 15, section 15.2 and 15.3 of Law on Value Added Tax, I hereby agree and confirm the Bank will send following information to relevant tax office: citizen's ID number, transfer amount and debit card account number that are related to non-cash transfer.

Зөвшөөрөл өгсөн / Approved by: /
 (Гарын үсэг / Signature) (Харилцагчийн овог, нэр / Surname, First Name)

Би дээрх мэдээллийг үнэн зөв болохыг баталж байна.
 Би Улаанбаатар хотын банкны төлбөрийн карт эзэмших гэрээний нөхцлийг хүлээн зөвшөөрч энэхүү маягтыг бөглөсөн болно.
 I confirm that all information given above are correct and accurate.

Баталгаат гарын үсэг / Authorised signature

Огноо/Date:

Банкны тэмдэглэгээ / For bank use only

Харилцагчийн № / Customer №:
 Дансны № / Account №:
 Картын № / Card №:
 Хүлээн авсан / Received by: нэр/name гарын үсэг/signature
 Хянасан / Approved by: нэр/name гарын үсэг/signature



20... оны ...-р сарын ... өдөр

№...

Улаанбаатар хот

Энэхүү Дотоодын төлбөрийн дебит карт эзэмших гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г нэг талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай, 11 хаягт байрлах Улаанбаатар хотын банк (цаашид "Банк" гэх), нөгөө талаас овогтой РД: (цаашид "Карт эзэмшигч" гэх, хамтад нь "Талууд" гэх) нар доорх нөхцөлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Гэрээний зорилго нь Банк аливаа этгээдийн дотоод хэрэглэгдэх төлбөрийн карт эзэмших тухай хүсэлтийг хүлээн авч, карт олгох, карт эзэмшигч нь өөрийн картаар төлбөр тооцоо хийх, үүнтэй холбогдох үйлчилгээг үзүүлэх, үйлчилгээний шимтгэл, хөрсийг банканд төлөх болон холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гэрээнд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.2.1. "Карт" гэж карт гаргагчаас банканд дахь данстай нь холбогдоноор карт эзэмшигчид төлбөр тооцоонд ашиглах боломж олгодог, олон улсад зөвшөөрөгдсөн картын байгууллагын стандарт болон Монголбанкнаас тавьсан шаардлагыг хангасан төлбөрийн хэрэгслийг;
 - 1.2.2. "Пин код" гэж төлбөрийн карт эзэмшигчийг картын жинхэнэ эзэмшигч гэдгийг нотлох 4-6 оронтой нууц кодыг;
 - 1.2.3. "CVV код" гэж картын пластикийн арын хэсэгт байрлах картын дугаарын ард тусдаа тэмдэглэгдсэн 3 оронтой тоог;
 - 1.2.4. "Интернет пин код" гэж КЭ өөрийн картаа ашиглан интернет худалдан авалт хийхэд тухайн КЭ гэдгийг нотлох 4 оронтой нууц дугаарыг;
 - 1.2.5. "Картаар үйлчлэгч байгууллага" (цаашид "КҮБ" гэх) гэж бараа, ажил үйлчилгээний төлбөрийг карт болон цахим мэдээ үүсгэгчийн тусламжтайгаар банканд дахь харилцах дансандаа хүлээн авдаг хувь хүн, хуулийн этгээдийг;
- 1.3. Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд мөрдөгдөж байгаа Банкны үйлчилгээний хүү шимтгэлийн шимтгэлийн ерөнхий нөхцөл болон түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд болон Карт ашиглах заавар нь Гэрээний салшгүй хэсэг байна;

Хоёр. Карт олгох

- 2.1. Карт эзэмших хүсэлт гаргагч этгээдээс ирүүлсэн дор дурдсан баримт бичгийг үндэслэн ажлын 3-5 хоногийн дотор карт олгоно. Үүнд:
 - 2.1.1. Дотоодын төлбөрийн дебит карт эзэмших хүсэлт;
 - 2.1.2. Иргэний үнэмлэх эсвэл гадаад паспорт;
 - 2.1.3. Цээж зураг;
 - 2.1.4. Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлд заасны дагуу картын дансандаа заавал байлгах үлдэгдэл, жилийн хураамж болон картын үнийг төлсөн байх.

Гурав. Банкны эрх, үүрэг

- 3.1. Банк дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 3.1.1. Карт эзэмшигчид картыг эрхэн хэрэглэх талаар заавар, зөвлөмж өгөх;
 - 3.1.2. Карт эзэмшигчийн дансны үлдэгдэл Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл (цаашид "Хүү, шимтгэлийн нөхцөл" гэх)-д заасны дагуу хүү тооцож олгох;
 - 3.1.3. Карт эзэмшигч шинээр карт авах, дэд карт нээлгэх, картын хугацаа сунгуулах, алдаж үрэгдүүлсэн, гэмтсэн карт дахин авах талаар бичгээр гаргасан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;
 - 3.1.4. Карт эзэмшигч төлбөр төлсөн бараа, үйлчилгээг буцаасан эсвэл илүү дүнгээр гүйлгээ хийсэн бол холбогдох дүнг ур КҮБ-ын бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн харилцагчийн картын данс руу буцаан олгох;
 - 3.1.5. Картын төлбөр, тооцоотой холбогдон карт эзэмшигч болон банктай гэрээ байгуулсан КҮБ-ын хооронд үүссэн маргаантай асуудлыг карт эзэмшигч, КҮБ хоёрын аль нэг талын хүсэлтээр 3 талын оролцоотойгоор хамтран шийдвэрлэх;
 - 3.1.6. Карт эзэмшигчийн картаараа хийсэн төлбөр, тооцоог картын данснаас тухай бүр гүйцэтгэж байх;
 - 3.1.7. Банк, бусад банк банкны сүлжээнд гарсан төлбөр тооцоотой холбоотой маргааныг Гэрээ, Монголбанкны Төлбөрийн картын журам, "Улаанбаатар хотын банкны төлбөрийн картын маргаантай гүйлгээг шалгах болон шийдвэрлэх журам" болон бусад хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх;
 - 3.1.8. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Карт эзэмшигчийн Банкинд эзэмшиж буй картын дансанд орлого, түүнтэй адилтгах бусад орлогод оногдох албан татвар, суутгалыг хууль тогтоомжид нийцүүлэн суутгах, холбогдох татварын байгууллагад шилжүүлэх;
 - 3.1.9. Карт эзэмшигчийн данс болон бусад мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд чандлан хадгалах;
- 3.2. Банк дараах эрх эдэлнэ. Үүнд:
 - 3.2.1. Картын үйлчилгээний хүү, шимтгэл, хураамжийг Хүү, шимтгэлийн нөхцөлд заасны дагуу карт эзэмшигчийн картын данснаас үл маргах журмаар суутган авах;
 - 3.2.2. Зах зээлийн нөхцөл байдлаас хамраарч Банкны дотоод шийдвэрээр гэрээнд өөрчлөлт оруулах;
 - 3.2.3. Карт эзэмшигчийн картаараа хийсэн төлбөр, тооцоог тухай бүр холбогдох данснаас нь суутган авч байх;
 - 3.2.4. Карт эзэмшигчийн худалдан авсан бараа, үйлчилгээний төлбөр дутуу эсвэл буруу суутгагдсан талаар КҮБ-аас хүсэлт гаргасан тохиолдолд холбогдох баримтыг карт эзэмшигчид танилцуулсны үндсэн дээр зөрүү дүнг картын данснаас суутгах, карт эзэмшигчтэй холбогдож чадаагүй бол тухайн дүнгээр дансанд хаалт тавих;
 - 3.2.5. Картын захиалагч өгч, хэвлүүлснээс хойш 6 сарын хугацаанд банкнаас картаа авч ашиглаагүй бол картыг хүчингүй болгох;
 - 3.2.6. Сүүлийн 2 жилийн хугацаанд картын дансаараа гүйлгээ хийгээгүй, дансны үлдэгдэл нь заавал байлгах үлдэгдлийн доод хэмжээг хангаагүй тохиолдолд карт болон картын дансыг хаах;
 - 3.2.7. АТМ-д хураагдсан картыг тухайн өдрөөс хойш 3 сарын хугацаанд банкнаас аваагүй бол картыг хүчингүй болгох;
 - 3.2.8. Карт эзэмшигчийн буруугаас Банк, КҮБ болон бусад хохирол учирсан нь тогтоогдсон бол карт эзэмшигчийн картын болон бусад данснаас суутган авах, дансан дахь үлдэгдэл нь хохирлыг бүрэн барагдуулж хүрэхгүй тохиолдолд хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авах;
 - 3.2.9. Карт эзэмшигч нь гэрээгээр хүлэсэн үүргээ биелүүлээгүй бол гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, гүйлгээ хийх эрхийг зогсоох;

Дөрөв. Карт эзэмшигчийн эрх, үүрэг

- 4.1. Карт эзэмшигч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 4.1.1. Дансанд заавал байлгах үлдэгдлийг тогтмол байршуулах;
 - 4.1.2. Банкны хүү, шимтгэлийн нөхцөлд заасан хураамж, шимтгэлийг төлөх үүрэгтэй бөгөөд картын данснаас хураамж, шимтгэлийг суутгах эрхийг Банканд үүгээр олгох;
 - 4.1.3. Дансыг хамтран эзэмших эрх бүхий нэмэлт карт эзэмшигчийн картаар хийсэн төлбөр, тооцоог болон түүнтэй холбогдон үүсэх маргаан, эрсдэлийг бүрэн хариуцах;
 - 4.1.4. Карт эзэмшигчийн талаарх мэдээллийг өөрчлөгдөх бүрд Банканд мэдэгдэж шинэчлүүлж байх, мэдэгдээгүйн улмаас үүсэх аливаа хохирлыг бүрэн хариуцах;
 - 4.1.5. Дотоодын бусад банкны сүлжээнд картаар хийгдсэн гүйлгээнээс үүдсэн нэмэлт хүү, шимтгэл, ханшийн зөрүүг бүрэн хариуцах;
 - 4.1.6. Картын нууцлал болох картын дугаар, хүчинтэй хугацаа, CVV, картын пин код, интернет пин кодын нууцлалыг нарийн чанд хадгалах, бусад мэдэгдэхгүй байх, картаа бусад ашиглуулахгүй байх үүрэгтэй бөгөөд картын нууцлалаа алдсанаас үүсэх аливаа эрсдэл, хохирол зардлыг бүрэн хариуцах;
 - 4.1.7. Дансны гүйлгээний хуулыг тогтмол шалгаж, маргаантай буюу хүлээн зөвшөөрөхгүй ямар нэгэн гүйлгээ хийгдсэн тохиолдолд тухайн өдрөөс хойш хуанлийн 14 хоногийн дотор банканд мэдэгдэж шалгуулах, мэдэгдээгүй эсвэл 14 хоногоос хойш мэдээллийн улмаас үүсэн хохирлыг КЭ өөрөө бүрэн хариуцах;
 - 4.1.8. Картын гүйлгээтэй холбоотой үүсгэсэн маргааныг шалгах явцад карт эзэмшигч нь Гэрээгээр хүлэсэн үүрэг болон төлбөрд карт хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрчсөн болох нь нотлогдсон тохиолдолд гарсан хохирол зардлыг бүрэн хариуцах;
 - 4.1.9. Өөрийн карт буюу пин кодыг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан, өөрийн данснаас эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн болон бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн, өөрийн картын пин кодыг гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд Банкны Харилцагчийн мэдээллийн төвийн /1800-1800, 11-319041/ дугаарын утсанд нэн даруй мэдэгдэж картаа хаалгах бөгөөд Банканд мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг өөрөө бүрэн хариуцах;
 - 4.1.10. Картаа хаалгаснаас хойш тус картаар өмнө нь хийсэн аливаа гүйлгээний нэхэмжлэл, авлага ирвэл карт эзэмшигч өөрөө хариуцах;
 - 4.1.11. Банкны харилцагчийн мэдээллийн төвөөр буюу зайнаас үйлчилгээ авсантай холбоотой үүссэн аливаа маргаан, хохирол зардлыг карт эзэмшигч өөрөө бүрэн хариуцах;
 - 4.1.12. Виза, Монголбанк болон төлбөрийн системд оролцогч бусад байгууллагуудын сүлжээнд карт эзэмшигчийн хийсэн гүйлгээ, тухайн гүйлгээний валютын төрөл, ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан үүсч болох ханшийн зөрүү, Виза, Монголбанк болон төлбөрийн системд оролцогч бусад байгууллагуудын зүгээс Банкны хүү шимтгэлийн ерөнхий нөхцөлөөс гадна нэмж тооцох үйлчилгээний нэмэгдэл төлбөр, хураамж, шимтгэлийг карт эзэмшигч бүрэн хариуцах;
- 4.2. Карт эзэмшигч дараах эрх эдэлнэ. Үүнд:
 - 4.2.1. Банкнаас өөрийн дансны үлдэгдэл болон гүйлгээний талаар хуулга, мэдээ, тайлбар авах;
 - 4.2.2. Банканд бичгээр хүсэлт гаргаж, данс хамтран эзэмших эрхтэй дэд картыг бусад олгуулах;
 - 4.2.3. Эзэмших буй картаараа дамжуулан Банкнаас үзүүлж буй нэмэлт үйлчилгээ авах;
 - 4.2.4. Картын хүчинтэй хугацаа нь дууссан, гэмтсэн, алдаж үрэгдүүлсэн бол карт нөхөж авах, пин кодоо мартсан бол шинээр авах хүсэлтийг Банканд гаргаж, шийдвэрлүүлэх;
 - 4.2.5. Өөрийн хүсэлтээр хугацаанаас нь өмнө Гэрээг цуцлах;
 - 4.2.6. Картаар нэг өдөрт хийх гүйлгээний лимитийг өөрчлүүлэх;
 - 4.2.7. Маргаантай буюу тодруулах шаардлагатай картын гүйлгээний талаар гүйлгээ хийгдсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Банканд хандах;
 - 4.2.8. Банкны терминалаар дамжуулан төлбөр тооцоо хийх;
 - 4.2.9. Гэрээгээр хүлэсэн үүргээ биелүүлэхийг Банкнаас шаардах.

Тав. Картаар хийх гүйлгээ болон ашиглалтад хязгаарлалт тавих

- 5.1. Карт ашиглалт, гүйлгээний аюулгүй байдлыг хангах үүднээс Банк дараах хязгаарлалтуудыг тогтооно. Үүнд:
 - 5.1.1. Банкны салбар, тооцооны төвөөс нэг өдөрт авах бэлэн мөнгөний дээд хэмжээ, гүйлгээний тоо;
 - 5.1.2. Үйлчилгээний байгууллагаар өдөрт үйлчлүүлэх гүйлгээний тоо, дээд хэмжээ;
 - 5.1.3. Нэг өдөрт АТМ-аас бэлэн мөнгө авах гүйлгээний тоо, дээд хэмжээ;
 - 5.1.4. Картын пин код АТМ-д алдаатай оруулах тоо;
 - 5.1.5. АТМ-д ямар нэгэн үйлдэл хийгээгүйгээс картыг хураан авах хугацаа;

Зургаа. Маргаан шийдвэрлэх

- 6.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг Талууд эвийн журмаар шийдвэрлэнэ.
- 6.2. Талуудын хооронд үүсэх маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэрээний хугацаа, гэрээ дуусгавар болох

- 7.1. Гэрээний хугацаа нь картын хугацаатай ижил байх ба карт хүчинтэй байх хугацаанд Гэрээний бүх заалтууд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 7.2. Гэрээний нөхцөл бүрэн биелэгдэж Гэрээ цаашид сунгагдахгүй болсноор буюу Гэрээг аль нэг талын санаачлагаар хугацаанаас өмнө цуцалснаар дуусгавар болно.
- 7.3. Хэрвээ Карт эзэмшигч нь картын данстай холбогдох аливаа өр, төлбөрийг бүрэн барагдуулаагүй бол тухайн төлбөрийг хүүгийн хамт бүрэн барагдуулж дуустал картын дансанд хаалт тавьж, барагдуулж дууссан өдрөөс Гэрээг цуцалж, гэрээний хугацааг дуусгавар болсонд тооцно.

Найм. Бусад зүйл

- 8.1. Гэрээ нь Талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 8.2. Гэрээг хоёр хувь үйлдэж, хоёр тал тус бүр нэг хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан:

Гэрээний нөхцөлийг бүрэн уншиж танилцсан бөгөөд гэрээний нөхцөл болон картын үйлчилгээний хүү, шимтгэлийг хүлээн зөвшөөрч баталгаат гарын үсгээ зурав.

Банкийг төлөөлж: /...../

Харилцагч: /...../

/Баталгаат гарын үсэг/

/Овог, нэр/